

**ОРЛОГО БА ХӨРӨНГИЙН ТАТВАРЫН ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС, МОНГОЛ УЛС
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР /КОНВЕНЦИ/**

Бүгд Найрамдах Австри Улс болон Монгол Улс,

**Орлого ба хөрөнгийн татварын тухай хэлэлцээр /Конвенци/-
ийг байгуулахыг эрмэлзэн**

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээд

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээд

Энэхүү Хэлэлцээр /Конвенци/ нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу тэдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдэд хамаарна.

2 дугаар зүйл. Хамаарагдах татварууд

1. Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс орлого ба хөрөнгөд ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т хамаарна.

2. Орлого ба хөрөнгөд ногдуулж буй татвар гэж нийт орлого буюу нийт хөрөнгө болон орлого буюу хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, аж ахуйн нэгжээс олгож буй цалин хөлсний нийт хэмжээнд болон хөрөнгийн үнэлгээний өсөлтөд ногдуулах татварыг хэлнэ.

3. Одоо хэрэглэгдэж байгаа, хамаарах татваруудад:

а) Австри Улсын хувьд:

- 1/ орлогын албан татвар;
- 2/ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
- 3/ газрын татвар;
- 4/ хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн нэгжүүдийн татвар;
- 5/ ашиглалтгүй газрын үнэлгээнд ногдуулах татвар.

(цаашид "Австрийн татвар" гэх)

б) Монгол Улсын хувьд:

- 1/ хүн амын орлогын албан татвар;
 - 2/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар;
 - 3/ үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар.
- (цаашид "Монголын татвар" гэх)

4. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/ нь одоо хэрэглэгдэж буй, татваруудтай адил буюу үндсэндээ төстөй бөгөөд энэ Хэлэлцээр /Конвенци/-т гарын үсэг зурсанаас хойш тэдгээрийн оронд шинээр бий болсон, эсвэл нэмэлт байдлаар

ногдуулсан татваруудад мөн адил хамаарна. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрсдийн холбогдох татварын хуулиудад орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар харилцан мэдэгдэнэ.

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т доорхи нэр томъёог өөрөөр заагаагүй бол дараахь утгаар ойлгоно. Үүнд:

а) "Хэлэлцэн тохирогч Улс" болон "Хэлэлцэн тохирогч нөгөө Улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Австри болон Монгол улсыг хэлнэ;

б) "Австри" улс гэж Бүгд Найрамдах Австри Улсыг хэлнэ;

в) "Монгол" гэж газар зүйн утгаар авч үзвэл, Монгол Улсын нутаг дэвсгэр бөгөөд Монгол Улсын татварын хууль үйлчлэх аливаа газар нутаг, түүнчлэн олон улсын эрх зүйн дагуу Монгол Улс өөрийн байгалийн баялгийг ашиглах бүрэн эрхээ хэрэгжүүлэх газар нутаг болон түүний нутаг дэвсгэр дээрх агаар мандлыг хэлнэ;

г) "этгээд" гэж хувь хүн, компани болон аливаа бусад этгээдийг хэлнэ;

д) "компани" гэж татварын утгаараа аж ахуйн нэгж хэмээн тооцогдох аливаа этгээд, аж ахуйн нэгжийг хэлнэ;

е) "Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж" буюу "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгж буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ;

ё) "олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг аж ахуйн нэгжийн явуулж буй усан онгоц, нисэх онгоцны тээврийн аливаа үйл ажиллагааг хэлнэ. Харин зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь газар нутгийн хооронд хөлөг онгоц, нисэх онгоцоор хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна;

ж) "эрх бүхий байгууллага" гэж,

1/ Австри Улсын хувьд Холбооны Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ;

2/ Монгол Улсын хувьд Санхүү, эдийн засгийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ;

з) "харьяат" гэж

- i) Хэлэлцэн тохирогч Улсын харьяат иргэн;*
- ii) Хэлэлцэн тохирогч Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу өөрийн статус бүхий аливаа хуулийн этгээд, нөхөрлөл, эсвэл нэгтгэлийг хэлнэ;*

2. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т тодорхойлоогүй аливаа нэр томъёог, Хэлэлцээр /Конвенци/-т өөрөөр заагаагүй бол, Хэлэлцээр /Конвенци/-т хамаарагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч Улсын тухайн үед хэрэглэгдэж буй хуульд заасан утгаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Байнга оршин суугч

1. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т "Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч" гэж тэр Улсын хуулийн дагуу оршин сууж, амьдарч буй болон тэр Улсад голлох удирдлага нь байрлаж байгаа буюу байгуулагдсан, адилтгах бусад шалтгаанаар тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Гэхдээ энэхүү нэр томъёонд зөвхөн энэ Улсад бий болсон эх үүсвэрээс олсон орлого буюу тэнд байрладаг хөрөнгөд тэр Улсад татвар төлөх аливаа этгээдийг хамруулахгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч этгээдийн статусыг дараахь байдлаар тодорхойлно.

а) байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв уг этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.

б) хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох аргагүй, эсвэл тэрээр Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол хэвшмэл байдалтайгаар оршин амьдардаг Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч гэж тооцно.

в) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь хэвшмэл байдлаар оршин амьдардаг, эсвэл алинд нь ч хэвшмэл байдлаар оршин амьдардаггүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харъяат байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно.

г) хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины нь харъяат эсвэл алиных нь ч харъяат биш бол тус асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь хүнээс бусад хуулийн этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршдог бол түүний голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг бизнесийн байнгын байрлалыг хэлнэ.

2. "Төлөөлөгчийн газар" гэдэгт тухайлбал;

а) аж ахуйг удирдан явуулж буй газар;

б) салбар байгууллага;

в) албан контор;

г) үйлдвэр, завод;

д) цех, тасаг;

е) уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, ил уурхай буюу байгалийн аливаа бусад ашигт малтмал олборлож буй газар.

3. 12 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилгын талбай дахь барилга байгууламж, угсралт буюу суурилуулалтын төслийн үйл ажиллагааг багтаана.

4. "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараахь үйл ажиллагааг үл хамааруулна. Үүнд:

а) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсыг хадгалах, үзүүлэх зорилгоор аливаа байгууламжийг ашиглах;

б) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг зөвхөн хадгалах, үзүүлэх, нийлүүлэх зорилгоор байлгах;

в) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг өөр аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор байлгах;

г) аж ахуйн нэгж нь зөвхөн өөртөө зориулан бараа буюу эд агуурс худалдан авах эсвэл мэдээлэл цуглуулах зориулалтаар тогтмол ажлын байртай байх;

д) аж ахуйн нэгж нь зөвхөн өөртөө зориулан аливаа бусад бэлтгэх болон туслах шинж чанартай үйл ажиллагаа явуулах зорилгоор тогтмол ажлын байртай байх;

е) а-д дэд хэсгүүдэд дурьдсан үйл ажиллагааг нэгэн зэрэг явуулдаг тогтмол ажлын байр нь бэлтгэх буюу туслах шинж чанартай байвал тухайн тогтмол ажлын байрыг Төлөөлөгчийн газарт үл хамааруулна.

5. 1 болон 2 дугаар заалтыг үл харгалзан, 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тухайн этгээдийн үйл ажиллагаа нь 4 дүгээр заалтаар хязгаарлагдахгүйгээр тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр байгуулах эрхийг байнга эдлэн тогтмол ажлын байрнаас үйл ажиллагаагаа явуулдаг бол түүнийг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ.

6. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, үндсэн төлөөлөн-борлуулагч (дистрибүтор), бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэх үндэс болохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно.

7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаа (төлөөлөгчийн газраар дамжуулах буюу бусад аргаар) явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтад байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгийн орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод (хөдөө аж ахуй болон ойн аж ахуйгаас олсон орлогыг оролцуулан) Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд заасны дагуу тодорхойлно. Аль ч тохиолдолд, уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйд ашиглагдаж буй мал, тоног төхөөрөмж, газарт суурилагдсан хөрөнгөтөй холбоотой хуулийн үндэслэл бүхий эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг эзэмшин ашиглах эрх, ашигт малтмалын нөөц, рашаан ус болон байгалийн бусад баялгийг ашигласны төлөө буюу ашиглах эрхийн төлөө төлөх байнгын бус болон тогтмол төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай буюу төмөр замын тээврийн хэрэгсэл үл хөдлөх эд хөрөнгөд үл тооцогдоно.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээ үзүүлэхэд ашигласан үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн тэр Улс татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар үйл ажиллагаа эрхэлж байвал уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн байнгын төлөөлөгчийн газарт шууд буюу шууд бусаар хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагааг, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар

заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрийн хувьд тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо тус төлөөлөгчийн газрын аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад өөрийн оршин байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад Улсад зарцуулсан аж ахуйн зардлыг, үүнд: ерөнхий ба удирдлагын захиргааны зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсад аливаа аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт ашгийг хуваарилдаг аргаар төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт ямар ч тохиолдолд саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэхүү зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Төлөөлөгчийн газар нь харьяалагдах аж ахуйн нэгждээ зориулан бараа буюу эд агуурс худалдан авсаныг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүлэн, төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлохдоо өөрчлөх баттай үндэслэлгүй бол жилээс жилд тогтсон нэг арга хэрэглэнэ.

7. Хэрэв ашиг нь энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн бусад зүйлд хамааралтай орлогын төрлийг өөртөө агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8. Энэ зүйлд заасан "ашиг" гэсэн тодорхойлолт нь нөхөрлөл болон түүнтэй адил байдлаар татварын тооцоо хийдэг хуулийн этгээдийн гишүүний олж буй ашиг, Австрийн хувьд Австрийн хуулийн дагуу байгуулагдсан нөхөрлөлийн гишүүний ашгийг хамаарна.

8 дугаар зүйл. Олон улсын тээвэр

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн усан онгоц, нисэх онгоцны тээврийн хэрэгслээр олон улсын тээвэр хийж олсон ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Дотоодын усан тээврийн үйл ажиллагаа явуулдаг усан онгоцны олсон ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн

удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

3. Хэрэв усан замын тээврийн байгууллагын голлох удирдлага нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол энэхүү хөлөг онгоцны харъяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад, хэрэв харъяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад голлох удирдлага нь байрладаг гэж үзнэ.

4. 1 дүгээр заалт нь аж ахуйн хамсрал (pool), хамтарсан үйлдвэр болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл. Хоршсон аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а) Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог, буюу

б) тухайн этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол, тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцлөөс ялгаатай бөгөөд тухайн аль нэг аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулж болно.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Улс нь тухайн улсын аж ахуйн нэгжийн ашигт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжид ногдуулсан татварын ашгийг нэмж тооцсон бөгөөд нэмж тооцсон ашиг нь тухайн хоёр аж ахуйн нэгжүүд хоорондоо хамааралгүй байх тохиолдолд, Хэлэлцэн тохирогч эхний Улсын аж ахуйн нэгжийн ашиг байхаар бол, Хэлэлцэн тохирогч нөгөө Улс нь тухайн ашигт ногдуулсан татварын хэмжээнд зохих залруулга хийнэ. Ийм залруулгыг хийхдээ энэхүү Хэлэлцээр /конвенци/-ийн бусад заалтуудыг харгалзан үзэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд энэ талаар харилцан зөвлөлдөнө.

10 дугаар зүйл. Ногдол ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн ногдол ашигт нөгөө Улс татвар ногдуулж болно. Гэхдээ ногдол ашиг төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улс тухайн ногдол ашигт өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох ба тухайн ногдуулах татварын хэмжээ нь дор дурдсан хувиас хэтэрч болохгүй:

а/ хэрэв ногдол ашиг хүртэгч нь нь ногдол ашиг төлж буй компанийн хөрөнгийн 10 хувийг шууд эзэмшдэг компани (нөхөрлөл бус) бол ногдол ашгийн нийт дүнгийн 5 хувиас;

б/ хэрэв ногдол ашиг хүртэгч нь тус ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч бол бусад бүх тохиолдолд ногдол ашгийн нийт дүнгийн 10 хувиас тус тус хэтрэх ёсгүй.

Энэхүү заалт нь тухайн компанийн ногдол ашиг төлөхөөс өмнөх ашигт ногдуулах татварт үл хамаарна.

2. Энэхүү зүйлд, "Ногдол ашиг" гэж хувьцааны ногдол ашиг, "жоуиссанс хувьцаа", "жоуиссанс эрх", өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрх болон бусад эрхээс үүсэх орлого мөн түүнчлэн ногдол ашгийн хуваарилалт хийж буй компанийн байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу хувьцааны ногдол ашгийн нэгэн адилаар татварт хамруулдаг аж ахуйн эрхээс олох орлогыг хэлнэ.

3. Хэрэв ногдол ашгийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд ногдол ашиг төлөгч компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг тогтмол байраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ба ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу тогтмол байр байгаатай шууд хамааралтай бол 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

4. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компаниас төлж буй ногдол ашигт татвар ногдуулахгүй байж болно. Энэ тохиолдолд гэхдээ тухайн ногдол ашгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлсөн эсвэл ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу тогтмол байр байгаатай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин төлсөн ногдол ашиг эсвэл хувиарлагдахгүй ашиг нь тухайн нөгөө Улсад бий болсон

орлого эсвэл ашгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн багтааж байлаа ч тухайн компаний хувиарлагдахгүй ашиг хувиарлагдахгүй ашгийн татварт хамрагдахгүй.

11 дүгээр зүйл. Хүү

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч хэрэв хүүгийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаг бол ногдуулах татварын хэмжээ нийт хүүний 10 хувиас хэтрэх ёсгүй.

3. 2 дугаар заалтыг үл харгалзан,

а/ Австри Улсад бий болж Монгол Улсын Засгийн газар болон Монгол Банкнд төлөгдсөн хүүг Австри улсад татвараас чөлөөлнө.

б/ Монгол Улсад бий болж Австри Улсын Засгийн газар болон Үндэсний Банкнд төлөгдсөн хүүг Монгол улсад татвараас чөлөөлнө.

в/ Бүгд Найрамдах Австри улсын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа Oesterreichische Kontrollbank AG-ны зээл болон түүний баталгаатай холбоотой төлөгдсөн хүүг Монгол Улсад татвараас чөлөөлнө.

4. Энэхүү зүйлд тусгагдаж буй "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөнд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан Засгийн газрын үнэт цаас зээллэгийн орлого, бүх төрлийн өрийн бичгийн орлого болон тухайн үнэт цаастай холбоотойгоор төлөгдөж буй шагнал урамшуулалын орлогуудыг хэлнэ. Хугацаа хожимдуулсны төлбөр нь энэ зүйлийн хувьд хүүд тооцогдохгүй.

5. Хэрэв хүү авах эрхийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл нөгөө Улсад оршдог тогтмол байрлалаас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь тухайн төлөөлөгчийн газар буюу тогтмол байрлалтай холбоотой бол

энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг мөрдлөгө болгохгүй. Энэ тохиолдолд 7 болон 14 дүгээр зүйлийн заалтуудыг аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу уг Улсын байнга оршин суугч бол хүүг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Улсад хүү бий болсон гэж үзнэ.

7. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвечийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

12 дугаар зүйл. Эрхийн шимтгэл

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж буй эрхийн шимтгэлд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол энэ зүйлийн 4 дүгээр заалтын "а" дэд заалтад хамаарах эрхийн шимтгэлд ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 10 хувиас хэтрэх ёсгүй.

3. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол энэ зүйлийн 4 дүгээр заалтын "б" дэд заалтад хамаарах эрхийн шимтгэлд ногдуулж буй татвар

нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 5 хувиас хэтрэх ёсгүй.

4. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй "эрхийн шимтгэл" гэсэн нэр томъёонд дараахь зүйлүүдтэй холбоотойгоор хийгдэж буй аливаа төлбөрүүд хамаарна.

а/ уран зохиол, урлаг, шинжлэх ухааны бүтээл түүний дотор киноны зохиогчийн эрхийг ашиглах, ашиглах эрхтэй холбоотой төлбөрүүд

б/ патент, барааны тэмдэг болон дизайн, модель, зураг төсөл болон нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, буюу үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөр хамаарна.

5. Хэрэв эрхийн шимтгэлийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг түүнчлэн эрхийн шимтгэлийн төлбөр авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Эрхийн шимтгэл төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улс өөрөө, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу уг Улсын байнга оршин суугч бол уг эрхийн шимтгэлийг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэлийн төлбөр төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл товлосон газраар дамжуулан эрхийн шимтгэлийн төлбөр төлөх үүрэг хүлээдэг бол тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газрын оршиж байгаа Улсад эрхийн шимтгэлийг бий болсон гэж үзнэ.

7. Эрхийн шимтгэлийн төлбөр төлөх болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчид буюу тэдгээрийн болон бусад хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлөгдсөн эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл

энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар эсвэл бүх аж ахуйн газрын хамт) буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй усан онгоц, нисэх онгоц, дотоодын усан замын тээврийн үйл ажиллагаа явуулж буй усан онгоцууд буюу эдгээр усан онгоц, нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

4. 1, 2 болон 3 дугаар заалтуудад дурдсанаас бусад аливаа хөрөнгийг борлуулснаас олсон орлогод зөвхөн борлуулагч байнга оршин суугч улсад татвар ногдуулна.

14 дүгээр зүйл. Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчаас мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Гэхдээ дараахь нөхцөлд уг орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно. Хэрэв байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагааг явуулахад байнга ашиглаж болох тогтмол ажлын байртай бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улс түүний орлогын зөвхөн тухайн тогтмол ажлын байртай холбоотой хэсэгт татвар ногдуулж

болно. Хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад нийт байсан хугацаа нь тухайн хуанлийн жилийн 183 өдрөөс давсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд ногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэж шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол болон багшлах бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, мэс засалч, хууль, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл. Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад шагнал урамшилд 16, 18, 19 болон 20 дугаар зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч тухайн Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээний хөлсөнд олгосон цалин урамшилд Хэлэлцэн тохирогч эхний Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна.

а) цалин урамшил авагч нь 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол, мөн

б) цалин урамшлыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, мөн

в) цалин урамшлыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар буюу товлосон газар нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс олон улсын шугамд тээвэр хийж буй усан онгоц, нисэх онгоц дотоодын усан тээврийн үйл ажиллагаа явуулдаг усан онгоцонд ажилласантай холбоотойгоор төлөгдөж буй цалин урамшуулалд тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

16 дугаар зүйл. Захирлуудын цалин урамшил

Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн Захирлуудын зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагын гишүүний хувьд авсан цалин болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагнал урамшилд нөгөө Улсад татвар ногдуулж болно.

17 дугаар зүйл. Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч театр, кино жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч хоёр Улс эсвэл аль нэг Улс, тэдгээрийн засаг захиргааны нэгж, орон нутгийн засаг захиргааны улсын сангаас тухайн улсад хийж буй тоглолтыг санхүүжүүлж байвал жүжигчин тамирчдын тоглолтоос олсон орлогыг энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудад хамааруулахгүй. Энэ тохиолдолд тухайн орлогод зөвхөн жүжигчид тамирчдийн байнга оршин суудаг улс татвар ногдуулна.

18 дугаар зүйл. Тэтгэвэр

1. 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт зөвхөн тухайн Улсад татвар ногдуулна.

2. 1 дүгээр заалтыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргааны нэгж, орон нутгийн засаг захиргааны харьяа улсын нийгмийн даатгалын систем болон тусгай сангуудын бүрэлдхүүн хэсэг болох улсын сангаас төлж буй тэтгэвэр болон адитгах бусад төлбөрүүдэд зөвхөн тухайн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

19 дүгээр зүйл. Засгийн газрын алба

1.

а) Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс тэр Улсын Засгийн газар буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд олгох тэтгэврээс бусад цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адитгах бусад урамшилд зөвхөн Хэлэлцэн тохирогч тухайн Улсад татвар ногдуулна.

б) гэхдээ хэрэв уг ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч Улсад гүйцэтгэсэн бөгөөд уг хувь хүн нь мөн тэр Улсын байнга оршин суугч бол дараахь тохиолдолд түүнд олгох цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адитгах бусад урамшуулалд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна. Уг хувь хүн.

I/ тухайн Улсын харъяат бол,

II/ гагцхүү алба хаших үүднээс тухайн Улсын байнга оршин суугч болоогүй бол.

2.

а) Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сангаас олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

б) гэхдээ хэрэв уг ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэсэн бөгөөд уг хувь хүн нь мөн тэр Улсын байнга оршин суугч бол түүнд олгох цалин урамшуулалд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна.

3. Монгол Улс дахь Австрийн Гадаад Худалдааны төлөөлөгч болон тухайн төлөөлөгчийн газрын ажилтнуудад төлж буй цалин урамшуулалд энэ зүйлийн 1 дүгээр заалт мөн адил хамаарна.

4. Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хаасны хувьд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, адитгах бусад урамшуулал болон тэтгэвэрт 15,16, 17 ба 18 дугаар зүйлийн заалтууд хамаарна.

20 дугаар зүйл. Вагн нар болон судлаачид

1. Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газраар магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллеж, сургууль, боловсролын байгууллагууд болон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хичээл заах, лекци унших буюу судалгаа хийх үндсэн зорилгоор Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын оршин суугч байсан хувь хүний хичээл зааж, судалгаа хийж олсон аливаа орлогыг Хэлэлцэн тохирогч эхний Улсад хоёр жилийн хугацаагаар татвараас чөлөөлнө. Тухайн хувь хүний Хэлэлцэн тохирогч Улсад ирсэн өдрөөс эхлэн татвараас чөлөөлөх 2 жилийн хугацааг эхлэн тооцно.

21 дүгээр зүйл. Оюутнууд ба дадлага хийгчид

Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан Хэлэлцэн тохирогч Улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагч, дадлага хийгчийн өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхэд зарцуулах түүний дараах орлогыг Хэлэлцэн тохирогч эхний Улс татвараас чөлөөлнө.

а/ тухайн төлбөр нь Хэлэлцэн тохирогч тухайн Улсын гаднах эх үүсвэрээс хийгдэж байвал,

б/ Засгийн газар, шинжлэх ухаан, боловсрол, соёлын болон ашгийн төлөө бус байгууллагын тусламж, тэтгэлэг, шагнал байвал,

в/ хуанлийн жилийн дүнгээр нийтдээ 183 хоногоос хэтрэхгүй хугацаанд Хэлэлцэн тохирогч тухайн Улсад ажил хийж олсон орлого.

22 дугаар зүйл. Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн олж буй бөгөөд аль нэгэн газраас бий болсон, энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв орлого олгогч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж

байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн хуулийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас олж буй орлого нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын татварын хуулийн дагуу татвараас чөлөөлөгдөхөөр байвал Хэлэлцэн тохирогч эхний Улсад татвар ногдуулахгүй байж болно.

23 дугаар зүйл. Хөрөнгө

1. 6 дугаар зүйлд заасан үл хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн, Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байдаг хөрөнгөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Аж ахуйн нэгжийн байнгын төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны хөрөнгийн зарим хэсгийг бүрдүүлэгч хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн буюу бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх хөрөнгөөр илэрхийлэгдсэн хөрөнгөд төлөөлөгчийн газар буюу товлосон газар байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй усан онгоц, нисэх онгоц, дотоодын усан замын тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг усан онгоц болон болон уг усан онгоц, нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгөд зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

4. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн бусад бүх төрлийн хөрөнгөд зөвхөн Хэлэлцэн тохирогч тухайн Улсад татвар ногдуулна.

24 дүгээр зүйл. Давхар татварыг арилгах аргууд

1. Австри Улсын хувьд давхар татварыг дараахь байдлаар арилгана:

а) Австри Улсын байнга оршин суугч энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн заалтуудын дагуу Монгол Улсад татвар ногдуулах орлого олж эсвэл хөрөнгө эзэмшиж байвал Австри

Улс "б"-гээс "д" дэд заалтуудын дагуу тухайн орлого болон хөрөнгийг татвараас чөлөөлнө;

б) Австри Улсын байнга оршин суугч 10, 11, ба 12 дугаар зүйлийн дагуу Монгол Улсад татвар ногдуулах орлого олж байвал Австри Улс тухайн оршин суугчийн орлогод ногдуулах татвараас Монгол Улсад төлсөн татвартай тэнцүү хэмжээний татварыг хасч тооцно. Гэхдээ тухайн хасалт нь Монгол Улсад бий болсон орлоготой холбоотой дээрх хасалтыг хийхээс өмнө тооцсон татварын хэмжээнээс хэтэрч болохгүй;

в) энэ заалтын "б" дэд заалтад дурдсан хасалт хийхэд 10 дугаар зүйлийн 1 дэх заалтын "б" дэд заалт, 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 2 болон 3 дахь заалтуудад дурдсан орлогын хувьд Монголд ногдуулах татвар нь 10 хувь байна;

г) 10 дугаар зүйлийн 1 дэх заалтын "а" дэд заалтад дурдсан Монгол Улсад оршин суугч аж ахуйн нэгжээс Австри Улсад оршин суугч аж ахуйн нэгжид төлсөн ногдол ашгийг Австри Улсын дотоодын хуулийн холбогдох заалтуудын дагуу Австри Улсад татвараас чөлөөлнө;

д) энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн дагуу Австри Улсад оршин суугчийн олж буй орлого болон эзэмшиж буй хөрөнгө нь Австри Улсад татвараас чөлөөлөгдсөн бол тухайн оршин суугчийн үлдэх орлого буюу хөрөнгөд татвар ногдуулахдаа чөлөөлөгдсөн орлого болон хөрөнгийг оруулж тооцно.

2. Монгол Улсын хувьд татварын давхардлыг дараахь байдлаар арилгана. Монгол Улсад оршин суугч энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн дагуу Австри Улсад татвар ногдуулах орлого олж эсвэл хөрөнгө эзэмшиж байвал тухайн оршин суугчид Монгол Улсад ногдуулах татвараас Австри Улсад төлсөн татварыг хасч тооцож болно. Гэхдээ тус хасалт нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу тооцогдсон орлогын болон хөрөнгийн татварын хэмжээнээс хэтэрч болохгүй.

25 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч Улсын харъяат Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харъяатаас татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй нөхцөлд байх ёсгүй.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газрын татвар

төлөх нөхцлийг нөгөө Улсын түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцлөөс доогуур байлгаж болохгүй. Энэ заалт нь Хэлэлцэн тохирогч Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдыг иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчийн хувьд татвараас чөлөөлөх, хөнгөлөх, багасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.

3. 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 7 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 7 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү, эрхийн шимтгэл болон бусад төлбөрийг эхний Улсын байнга оршин суугч этгээдэд төлсөнтэй адил нөхцлөөр хасч хөнгөлнө. Үүний нэгэн адилаар, Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар ногдох хөрөнгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчид төлсөн аливаа өрийг эхэнд дурдсан Улсын байнга оршин суугчийн хувьд тохиролцсонтой адил нөхцлөөр хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд буюу шууд бусаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн өмчилж буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй байдалд оруулах хариуцлага ногдуулахгүй.

5. 2-р зүйлийн заалтуудыг үл харгалзан энэ зүйлийн заалтууд нь бүх төрлийн татварт хэрэглэгдэнэ.

26 дугаар зүйл. Харилцан тохирох журам

1. Хэрэв хувь этгээд Хэлэлцэн тохирогч аль нэг Улс буюу хоёр Улс хоёулаа энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т тусгагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулах боллоо гэж үзвэл тухайн Улсуудын дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсынхаа эрх бүхий байгууллагад буюу хэрэв тухайн тохиолдол нь 25 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад хамаарч байвал өөрийн харъяат Хэлэлцэн тохирогч Улсад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т тусгагдаагүй татвар ногдуулж байна гэж анх мэдсэнээс хойш 3 жилийн дотор гаргана.

2. Гомдлыг нотлож хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т тусгагдаагүй татвар ногдуулахгүй байх зорилгоор харилцан тохирох бүх арга хэмжээ авна. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээр /Конвенци/-т тусгагдаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд харилцан зөвлөлдөж болно.

4. Өмнөх заалтуудын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд хоорондоо шууд харьцаж болохоос гадна талуудын төлөөлөгчдөөс бүрдсэн хамтарсан комисс байгуулан ажиллаж болно.

5. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн тайлбар болон хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудлыг хэрэв энэ зүйлийн өмнөх заалтуудын дагуу эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд шийдвэрлэх боломжгүй бол Хэлэлцэн тохирогч Улсын эрх бүхий байгууллага нь харилцан тохиролцох журмын дагуу байгуулсан маргаан таслах шүүхэд асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Маргаан таслах шүүхэд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага бүрээс нэг нэг төлөөлөгч, Хэлэлцэн тохирогч Улс бүрээс нэг нэг бие даасан хараат бус маргаан таслагч шүүгчийг оролцуулна. Маргаан таслагчид нь тухайн орны дээд шүүхэд ажиллах чадвартай өөр нэг хүнийг даргаар томилно. Улс тус бүр маргаан таслагч шүүгчийн жагсаалтад эрх бүхий 5 хүнийг томилно. Татвар төлөгч нь өөрөө хүсвэл маргаан таслах шүүхэд даргаар оролцож болно. Маргаан таслах шүүх нь өөрийн шийдвэрийг хэрэг хэлэлцсэн өдрөөс хойш 6 сарын дотор гаргана. Шийдвэр нь хэрэгт холбогдол бүхий нийт татвар төлөгч болон Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины хэрэг тус бүрийг хамарсан байна.

27 дугаар зүйл. Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээр /Конвенци/-ийн заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна. Хэлэлцэн тохирогч Улс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас хүлээн авсан мэдээллийг Хэлэлцэн тохирогч Улс өөрийн улсын мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж зөвхөн энэхүү Конвенцид хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагуудад (шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан) мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд буюу эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно. Тухайн хүнтэй холбоотой мэдээллийн нууцлал нь өөр хувь хүний үндсэн болон хууль эрх зүйн ашиг сонирхол эсвэл нийгмийн үндсэн эрх ашгийг хөндөхөөр байвал түүнийг нийтэд ил болгохгүй.

2. 1 дүгээр зүйлийн заалтууд нь ямарч тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй.

а) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ хэрэгжүүлэх,

б) Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээлэл буюу баримт бичгээр хангах,

в) Аливаа худалдаа, бизнес, аж үйлдвэр, арилжааны буюу мэргэжлийн нууц, худалдааны процессийн талаарх мэдээлэл нь Хэлэлцэн тохирогч Улсын нийгмийн бодлого, үндсэн эрх ялангуяа мэдээлэл хадгалах эрхтэй зөрчилдөхөөр байвал тийм мэдээллээр хангах
28 дугаар зүйл. Дипломат ба консулын ажилтнууд

Энэхүү Хэлэлцээр /Конвенци/ нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу дипломат ба консулын ажилтнуудын санхүүгийн эрх дархыг үл хөндөнө.

29 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/ нь соёрхон батлагдах ёстой бөгөөд хоёр тал соёрхон баталсан баримт бичгийг аль болох хурдан хугацаанд харилцан солилцоно.

2. Энэхүү Хэлэлцээр /Конвенци/ нь түүнийг соёрхон баталсан тухай ноот бичиг харилцан солилцсон сараас эхлэн тоолсон дараагийн 3 дахь сарын 1-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд соёрхон баталсан тухай ноот бичиг харилцан солилцсон хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ны өдрийн дараагийн хуанлийн жилийн татваруудтай холбогдолтой заалтууд нь хэрэгжинэ эхэлнэ.

30 дугаар зүйл. Дуусгавар болох

Энэхүү Конвенцийг Хэлэлцэн тохирогч аль нэг Улс цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараахь хуанлийн жил дуусахаас 6 сараас өмнө уг Конвенцийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч аль ч Улс дипломат шугамаар бичгээр мэдэгдэж дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд энэхүү Конвенцийг дуусгавар болгох тухай мэдэгдэл өгсөн жилийн 12 дугаар сарын 31-ний дараагийн хуанлийн жилийн татваруудын хувьд Конвенц нь дуусгавар болно.

Энэхүү Конвенцийг Вена хотноо 2003 оны 7 дугаар сарын ...-ны өдөр герман, монгол, англи, хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтлана.



**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**



МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

ПРОТОКОЛ

Орлого ба хөрөнгийн татварын тухай Бүгд Найрамдах Австри Улс, Монгол Улсын хооронд байгуулах Хэлэлцээр /Конвенци/-т гарын үсэг зурах үед талууд дараах зүйлүүдийг тус Хэлэлцээр /Конвенци/-ийн салшгүй хэсэг гэж харилцан тохиролцсон болно.

Хэлэлцээр /Конвенци/-ийн тайлбар

Орлого ба хөрөнгийн татварын тухай Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын (ЭЗХАХБ) болон Хөгжиж буй орон болон Хөгжингүй орны хооронд байгуулах Давхар татварын Конвенцийн Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) татварын гэрээний үлгэрчилсэн загваруудын холбогдох заалтуудын дагуу байгуулсан энэхүү Конвенцийн заалтууд нь ерөнхийдөө ЭЗХАХБ болон НҮБ-ын гэрээний үлгэрчилсэн загварын тайлбарт дурдсантай ижил утгатай байна. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсоноос хойш эрх бүхий байгууллагууд хоорондоо харилцан тохиролцсон тайлбарын хувьд өмнөх өгүүлбэр үйлчлэхгүй. Тайлбар нь 1969 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Олон Улсын Гэрээний тухай Венийн Конвенцийн агуулгын дагуу тайлбар тодруулга хийх нэг хэрэгсэл бөгөөд энэ нь тодорхой цаг хугацаанд өөрчлөгдөж байдаг. Хэрэв ЭЗХАХБ болон НҮБ-ын гэрээний үлгэрчилсэн загварын тайлбарууд нь өөр өөр байвал 26 дугаар зүйлийн дагуу талууд харилцан тохиролцож нэгдмэл тайлбар хийнэ.

24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "в" заалтын нэмэлт:

Хэрэв тухайн үйлдэл нь үндсэндээ татвараас зайлсхийх зорилготойгоор хийгдсэн бол тус заалт энд үйлчлэхгүй.

Дээр дурдсаныг нотолж, Хэлэлцэн тохирогч хоёр Талын зохих ёсоор эрх олгогдсон этгээд энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү Конвенцийг Вена хотноо 2003 оны 7 дугаар сарын ...-ны өдөр герман, монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Энэхүү Протоколыг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтлана.

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ




